



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 31 өдөр

Дугаар 4/77

Хажуу шинэ үс

Авто машингүй өдөр болгох,
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хичээлийн шинэ жил эхэлж байгаатай холбогдуулан, хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, хүүхэд эцэг эх, гэр бүлтэйгээ хамтдаа зам тээврийн осолд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийг "Авто машингүй өдөр" болгон зарласугай.

2. Авто машингүй өдрийг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: С.Дугарбаатар (Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга)

Гишүүд: Э.Ванчиндорж (Хэсгийн төлөөлөгч)

Б.Наранбаатар (Хэсгийн цагдаа)

Б.Мөнхтөгөлдөр (1 дүгээр багийн Засаг дарга)

Г.Батчулуун (2 дугаар багийн Засаг дарга)

Б.Даваасүрэн (3 дугаар багийн Засаг дарга)

Л.Батбаатар (4 дугаар багийн Засаг дарга)

Т.Уранчимэг (Сургуулийн захирал)

А.Алтанчимэг (Цэцэрлэгийн эрхлэгч)

3.Авто машингүй өдрийн маршрутыг Засаг даргын Тамгын газрын баруун талын уулзвар, Цэцэрлэгийн баруун талын уулзвар, Сургуулийн баруун хойд, болон зүүн хойд талын уулзвар, Цагдаагийн хэсгийн хойд талын уулзваруудын хэсэг болон дотогш замыг өглөөний 08:00 цагаас 16:00 цагийн хооронд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түр хязгаарласугай.

4.Захирамжийн хэрэгжилтийг хангуулж, хяналт тавьж ажиллахыг Хэсгийн төлөөлөгч, дэслэгч (Э.Ванчиндорж), хэсгийн цагдаа, дэд ахлагч (Б.Наранбаатар) нарт үүрэг болгосугай.

Хавсрал 1... хуудас

ЗАСАГ ДАРГА



Ө.МӨНХ-АМГАЛАН

482201077